

Хараат бус тайлагналын механизм

Монгол улс дахь хамтын
оролцоот төлөвлөлтийн
товч тайлан 2023

Open
Government
Partnership



Independent
Reporting
Mechanism

Танилцуулга

Нээлттэй Засгийн Түншлэлийн (НЗТ) зүгээс бэлтгэн гаргаж буй энэхүү товч тайлан нь Монгол улсын НЗТ-ийн Үйл ажиллагааны үндэсний V төлөвлөгөөг хамтран (хамтын оролцоотой) боловсруулах үйл явц болон төлөвлөгөөний дизайнд дэмжлэг үзүүлэх, тусгагдаж буй үүрэг амлалтуудын чанар, тэмүүлж буй үр дүн, хэрэгжих боломжийг сайжруулах зорилготой юм. Энэхүү тайлан нь тухайн улсын нөхцөл дэх нээлттэй засгийн боломж, сорилтуудын талаарх тойм мэдээллийг хамаарах зөвлөмжүүдийн хамтаар тусгасан. Тухайн зөвлөмжүүд нь зөвхөн санал хэлбэртэй буйн зэрэгцээ энэхүү тайлан нь тодорхой нэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд хийгдсэн үнэлгээ бус болно. Тайлангийн зорилго нь Хараат бус тайлагналын механизмын хамтарсан, тухайн улс орны нөхцөл байдлыг харгалзсан судалгааны үр дүнд үндэслэн төлөвлөлтийн үйл явцыг мэдээллээр хангах явдал юм. Засгийн газар болон иргэний нийгэм нь хамтран дараагийн үйл ажиллагааны төлөвлөгөөний чиглэл, агуулгыг тодорхойлоход энэхүү тайлан нь эх сурвалж болно. НЗТ-ийн үндэсний оролцоогч талууд нь энэхүү тайланд заасан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх цар хүрээг тодорхойлно.

Хамтын оролцоот төлөвлөлтийн тайлан нь өмнө ирүүлсэн [НЗТ-ийн Монгол улсын тайлангууд](#) дээр хийсэн судалгааны үр дүн, эдгээр тайланд багтсан буй өгөгдөл мэдээлэл, дүгнэлтүүдийн зөвлөмж дээр үндэслэгдсэн. Тайлан нь мөн [НЗТ-ийн үндэсний гарын авлага](#), [НЗТ-ийн оролцоот, хамтын төлөвлөлтийн стандарт](#), болон ХБТМ-ын зүгээс бэлтгэн гаргасан [НЗТ-ийн минимум шаардлагуудын үнэлгээ](#) and ["Оролцоог хангахад" тавигдах минимум босго стандарт](#) зэрэг бусад эх сурвалж дээр суурилснаар өгч буй зөвлөмжүүд нь ХБТМ-ын тайлангууд бэлтгэгдсэн гарснаас хойш хугацаанд гарсан өөрчлөлтүүдийг багтааж, НЗТ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөний үүрэг амлалтуудын дизайн болон хэрэгжилт, мөн нээлттэй засгийн чиглэлийн үйл ажиллагаанд гарч буй тухайн нөхцөл байдалд нийцэх арга ажиллагааг зөвлөмжүүдэд тусгаж буй юм. Энэхүү хамтын оролцоот төлөвлөлтийн товч тайланг ХБТМ-ын ахлах экспертүүд тухайн нөхцөл байдалд хамааралтай, зөвлөмжүүдийг үйл ажиллагаанд тусгах боломжуудын хүрээнд хянан тохиолдуулж тайлангийн үнэн бодит, нийцтэй байдлыг хянан үзсэн. Боломжтой тохиолдолд товч тайланг хөндлөнгийн хянан магадлагч эсвэл ХБТМ-ын Олон улсын экспертийн бүлэг (IEP) хянан үздэг.

ХБТМ нь энэхүү хамтын оролцоот төлөвлөлтийн товч тайлангийн төслийг 2023 оны 7 дугаар сард бэлтгэн гаргасан.

Агуулга

Хэсэг I: Үйл ажиллагааны хамтын оролцоот төлөвлөлтийн үйл явц	2
Хэсэг II: Үйл ажиллагааны төлөвлөгөөний дизайн	4

Хэсэг I: Үйл ажиллагааны хамтын оролцоот төлөвлөлтийн үйл явц

Монгол улсын Үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөөнүүд нь татвар, төсөв, байгалийн нөөц баялаг, гэмт хэрэгтэй тэмцэх зэрэг чиглэлээр төрийн ил тод байдлын сайжруулж ирсний зэрэгцээ боловсрол болон эрүүл мэндийн салбар дахь иргэний оролцоог хангах боломжууд нээн өгчээ. Гэвч Монгол улсын Засгийн газарт гарч буй өөрчлөлтүүд нь талуудын оролцоог тогтвортой хангахад сорилт учруулж, үүрэг амлалтуудын биелэлт, урьдчилсан үр дүнгүүд нь НЗТ-ийн гишүүн орнуудын дунджаас доогуур байж иржээ. Монгол улс нь үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах явцад олон нийтийн зүгээс ирүүлсэн саналуудыг хэрхэн харгалзан үзсэн талаарх үндэслэл тайлбар бүхий хариуг өгөх замаар өөрийн хамтын оролцоот төлөвлөлтийн үйл явцыг улам сайжруулж ирсэн. Монгол улсын удахгүй бэлтгэн гаргах Үйл ажиллагааны үндэсний V төлөвлөгөөнд тусгагдах амлалт, эрмэлзлийг нэмэгдүүлэхийн тул иргэний орон зай, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдал, төрийн худалдан авах ажиллагаа болон зөвлөлдөх ардчиллын чиглэлээр өргөн хүрээний оролцогч талуудыг боломжуудыг үүсгэх боломжтой байна. ХБТМ нь мөн үр дүнд суурилсан үүрэг амлалтуудын төслийг бэлтгэн гаргах чиглэлээр дизайн сургалт семинар хийх боломжтой.

Хамтын оролцоот төлөвлөлтийн үйл явцыг сайжруулах зорилгоор ХБТМ-ын зүгээс дараах зөвлөмжүүдийг өгч байна:

ЗӨВЛӨМЖҮҮД

Зөвлөмж 1: НЗТ-ийн оролцооны үйл ажиллагаа, гарч буй ахиц дэвшлийн талаар нээлттэй, хүртээмжтэй, шуурхай мэдээллийг хангах

Өнгөрөгч жилийн хугацаанд Монгол улс нь НЗТ-ийн дотоодын вэбсайт хөгжүүлэх ажлыг эхлүүлсэн ч одоогоор тус вэбсайтад нэвтрэх боломжгүй байна. НЗТ-ийн [Оролцоо, хамтын оролцооны стандартад](#) заасан Стандарт 2 болон 3-ыг ханган биелүүлэхийн тулд НЗТ-ийн шинэчлэгдсэн вэбсайт болон мэдээллийн сан зайлшгүй байх шаардлагатай ба ингэснээр үлдэх стандартуудыг хангах боломж Монгол улсад нээгдэнэ. Түүнчлэн НЗТ-ийн Асуудал хариуцсан этгээд (Point of Contact) нь хамгийн минимум шатанд тухайн вэбсайт хэвийн ажиллаж, олон нийтэд нээлттэй байж, хамгийн сүүлд гарсан буй Үйл ажиллагааны төлөвлөгөөг хэвлэн нийтэлсэн байхыг шалган баталгаажуулж явдаг. [Румын](#) болон [Итали](#) улсууд нь НЗТ-ийн хэрэглэхэд хялбар вэбсайтуудын жишээг харуулна. ХБТМ-ын зүгээс вэбсайтад зориулан дараах зөвлөмжүүдийг өгч байна:

- **НЗТ-ийн Үндэсний зөвлөлийн суурь дүрэм, журам**, үүнд чиг үүрэг болон бүтэц, зургаан сар тутамд хуралдаж буй нотолгоог (Жишээ болгон [Австрали](#), [Морокко](#), [Шинэ Зеланд](#) улсуудын вэбсайтыг үзнэ үү) байршуулж байх.
- **Мэдээллийн санг** багадаа зургаан сар тутамд **шинэчилж** төлөвлөгөөний хэрэгжилт, хамтын оролцоот төлөвлөлтийн үйл явцын тухай шинэчилсэн мэдээлэл байршиж байхыг баталгаажуулж байх (Жишээ болгон [Австрали](#), [Йордан](#), [Шинэ Зеланд](#) болон [Филиппин](#) улсуудын мэдээллийн санг үзнэ үү).
- **Хамтын оролцоот төлөвлөлтийн цагалбар** болон оролцогч талуудын зүгээс оролцох боломжийн талаарх мэдээллийг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах үйл явц эхлэхээс багадаа 2 долоо хоногийн өмнө нийтэлж байх (Жишээ нь [Румын](#) болон [Нидерланд](#) улсуудын цагалбар).
- Үйл ажиллагааны төлөвлөгөөнд оролцогч талуудын зүгээс ирүүлсэн бүхий л **саналыг**, мөн эдгээрийг хэрхэн харгалзан тусгасан талаар **баримтжуулан**,

нийтэлж байх (Жишээ болгон [Канад](#), [Финланд](#) болон [Морокко](#) улсуудад хэрхэн баримтжуулсан болохыг үзнэ үү).

Зөвлөмж 2: Засгийн газар болон иргэний нийгэм хоорондын байнгын хэлэлцүүлэг, хамтын ажиллагааг үүсгэх

Өмнөх Үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөөг хамтын оролцоот байдлаар боловсруулах явцад Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах Ажлын хэсгийг байгуулан, Засгийн газар болон иргэний нийгэм хоорондын хэлэлцүүлгийн орон зайг ханган өгсөн. Гэвч Монгол улсад дахь Олон талын оролцоот форум нь тухайн төлөвлөгөөний хэрэгжилтийн хугацаанд байнга хуралдсангүй. 2020 оны эцсээр НЗТ-ийн Үндэсний зөвлөлийг өргөтгөсөн ч шинээр гишүүд сонгон шалгаруулах үйл явц нь оролцоог хангаагүй байна. НЗТ-ийн Оролцоо, хамтын оролцоот төлөвлөлтийн стандартад заасан 1 дүгээр стандарт ([Participation and Co-Creation Standards](#)) нь Засгийн газар болон иргэний нийгэм болон бусад төрийн бус төлөөллийн гишүүдийг оролцуулсан байнгын хэлэлцүүлгийн орон зайг ханган, энэ нь байнга (зургаан сард нэгээс доошгүй) хуралдаж, оролцооны үндсэн журам дүрмээ ил тод болгосон байхыг шаарддаг. Үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах явцад Үндэсний зөвлөлийн чиг үүрэг, бүтэц бүрэлдэхүүнийг иргэний нийгэмтэй (үүнд хүний эрхийн байгууллагуудын оруулж) хамтран тодорхойлж, ил тодоор мэдээлж байхыг ХБТМ-ын зүгээс зөвлөмж болгож байна. Жишээ нь [Филиппин](#) улсад Олон талын оролцоот форум дахь иргэний нийгмийн төлөөллийг салбарын болон төрийн бус байгууллагуудын хурлаас өөрсдөө сонгон тодруулжээ. Мөн Үйл ажиллагааны төлөвлөгөөг эцэслэх явцад энэхүү форум нь тодорхой чиг үүргийг гүйцэтгэхийн зэрэгцээ үүрэг амлалтуудын хамрах хүрээг иргэний нийгэмтэй зөвлөлдөлдөггүйгээр өөрчлөхөөс сэргийлэх нь чухал. 5 дугаар стандартыг хангахын тулд НЗТ-ийн Үндэсний зөвлөл нь төлөвлөгөөний хэрэгжилтийн мөчлөгийн хугацаанд үргэлжлүүлэн байнга буюу жилд 2-оос доошгүй, иргэний нийгмийг оролцуулан удаа хуралдаж, үүнд хэрэгжилтийн үр дүнг танилцуулан, иргэний нийгмийн зүгээс саналаа өгөх боломжийг хангах шаардлагатай.

Зөвлөмж 3: НЗТ-ийн үйл явц дахь Засгийн газрын оролцоог сайжруулах

Үйл ажиллагааны үндэсний V төлөвлөгөөнд зориулан ХБТМ-ын зүгээс хамтын оролцоотой төлөвлөх шатанд хамаарах яамдын шийдвэр гаргагчдын оролцоог эртнээс идэвхтэй хангах талаар ажиллахыг зөвлөмж болгож байна. Өмнөх Үйл ажиллагааны төлөвлөгөөнд улс төрийн тогтворгүй байдал нь хамтын оролцоот төлөвлөлт дэх Засгийн газрын манлайлалд сөрөг нөлөө үзүүлсэн. Түүнчлэн үүрэг амлалтуудыг хариуцах салбар яамдын ажилтнууд солигдсон нь институтийн мэдлэг дамжуулах, үйл явцын залгамж чанарыг хадгалах байдлын сааруулсан. Үр дүн бүхий нөлөө бүрдүүлэхийн тулд үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан санаачилгуудыг төрийн байгууллагууд бүрэн өөриймшүүлэн хэрэгжүүлэхийг шаарддаг. Өндөр түвшний албан тушаалтнуудын шууд оролцоо нь НЗТ-ийн үүрэг амлалтуудад бодлогын ямар чиглэл илүү бодитой, ямар нь улс төрийн хувьд хэрэгжүүлэхэд хүндрэлтэй болохыг тодруулахад дэм болно. Үүний жишээг [Хорват](#) улсын Олон талын оролцоот форум нь шийдвэр гаргах эрх бүхий эсвэл шийдвэр гаргагчидтай шууд харьцдаг төрийн өндөр албан тушаалтнуудыг бүрэлдэхүүндээ багтааснаас харж болно.

Үйл ажиллагааны үндэсний V төлөвлөгөөг хамтын оролцоотой боловсруулахад төрийн оролцоог дэмжин хангахын тулд Засгийн газар дахь Асуудал хариуцсан этгээд (РОС) нь хамаарах яамдын өндөр албан тушаалтнуудтай хийх хурал, уулзалтуудыг санаачилж болно. Засгийн газрыг төлөөлөх талуудад мэдээлэл өгөх уулзалтуудыг зохион байгуулахаас өмнө Асуудал хариуцсан этгээд нь Монгол улсын нөхцөлд нийцсэн, НЗТ-ийн

танилцуулгыг тоймлон бэлтгэн гаргаж болно. [Нигери](#) улсын гаргасан Оролцооны стратегид Асуудал хариуцсан этгээд нь хамтын оролцоот төлөвлөлтийн явцад яам бүрийн өндөр албан тушаалтантай нэг бүрчлэн уулзаж, оролцооны боломжуудын талаар мэдээлдэг ба үүнийг харгалзан үзэж болно. Үйл ажиллагааны бүхий л мөчлөгийн туршид хамаарах сайд эсвэл өндөр албан тушаалтнууд нь байнгын давтамжтай уулзан, гарч буй ахиц, тулгарч буй саад, сорилтуудыг шийдэх боломжуудын талаар хэлэлцэх байх боломжтой.

Зөвлөмж 4: Бодит, амбицтай зорилт бүхий үүрэг амлалтуудыг төлөвлөх

Өмнөх удаагийн Үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө нь олон сэдэвчилсэн чиглэл, салбаруудыг хамарсан. Гэвч үүнд тусгасан үүрэг амлалтууд нь амбицтай, бодит зорилтуудыг тэр бүр тусгаагүй. Цаашид хийгдэх дараагийн төлөвлөгөөний хамтын оролцоот үйл явцын хүрээнд гаргах үүрэг амлалтуудын дизайн нь өндөр зорилт бүхий тоон болон газар зүйн хамааралтай зорилтууд, мөн эдгээрийг хэрэгжүүлэх шаардлагатай санхүүгийн болон бусад нөөц үүсвэрийг тусгасан байх шаардлагатай. Тодорхой, ойлгомжтой цаг хугацааг гарган, өргөн хүрээнд зөвлөлдсөний үндсэн дээр тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлоход дэмжлэг болох зорилгоор ХБТМ-ын зүгээс бодлогын экспертүүд, хэрэгжүүлэгч байгууллагууд, мэргэжлийн мэдлэг чадвар бүхий ИНБ-уудыг хамтад нь оролцуулан үүрэг амлалтуудын бодлогын зорилтуудад дэмжлэг болохуйц тодорхой үйл ажиллагаануудыг тодорхойлон гаргахыг зөвлөмж болгож байна. Үйл ажиллагааны төлөвлөгөөг эцэслэн баталгаажуулахаас өмнө тусгасан буй үүрэг амлалтуудын төслүүдийг нягтлан үзэж үйл ажиллагаанууд нь бодлогын зорилтуудтай тодорхой уялдаатай, цаг хугацааны хувьд боломжтой эсэхийг баталгаажуулах шаардлагатай. Үүрэг амлалтуудын дизайн нь нээлттэй засгийн үүднээс тодорхой заагдсан, төрийн хэмжээнд буй өнөөгийн арга ажиллагаа, практикийг тогтвортой сайжруулсан байх ёстой. Жишээ нь хууль тогтоомжуудад үнэлгээ хийх чиглэлийн үүрэг амлалтын хувьд гарсан үр дүнг хууль эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг багтааж болно. Түүнчлэн давхацсан хугацаа, үйл ажиллагаа бүхий үүрэг амлалтуудыг нэг болгон нэгтгэж, хэрэгжүүлэгч талуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, төлөвлөх байдлаар тусгаж болно. Үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг НЗТ-ийн Дэмжих багт (OGP Country Support) хүргүүлэх зөвлөгөө, санал авч болно. ХБТМ нь мөн үр дүнд суурилсан үүрэг амлалтуудын төслийн гаргахад зориулан дизайн семинар зохион байгуулах боломжтой. Мөн НЗТ-ийн Үндэсний гарын авлага ([OGP National Handbook](#)) дээр зааснаас ашиглах боломжтой.

Хэсэг II: Үйл ажиллагааны төлөвлөгөөний дизайн

ҮҮРЭГ АМЛАЛТУУД АВАХ БОЛОМЖ БҮХИЙ ЧИГЛЭЛҮҮД

Үйл ажиллагааны үндэсний V төлөвлөгөө нь өмнөх төлөвлөгөөнд тусгагдсан иргэний орон зай, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдал, төрийн худалдан авах ажиллагаа зэрэг чиглэлийн үүрэг амлалтууд, хийгдсэн хүчин чармайлт дээр суурилж болно. Тодорхой амбиц бүхий зорилт багтаасан үүрэг амлалт авах боломжит нэг чиглэл нь зөвлөлдөх ардчилал байж болно.

ЧИГЛЭЛ 1. Иргэний орон зай

Иргэний орон зайг хамгаалах нь Монгол улс дахь нээлттэй засгийн үйл явцад хамаарах бодлогын чухал ач холбогдол бүхий чиглэл юм. Иргэд чөлөөтэй сэтгэж, ярьж, дуугардаг,

зохицуулалттайгаар үйл ажиллагаа явуулдаг, өөрчлөлтийн төлөө нөлөөлдөг орон зай, орчин бүрдсэн үед л нээлттэй засгийн шинэчлэл хийгдэх боломжтой. Одоогоор CIVICUS (Иргэний нийгмийн байгууллага, идэвхтнүүдийн олон улсын эвсэл) байгууллагын зүгээс Монгол улсад иргэний орон зай [хумигдсан](#) хэмээн дүгнэж байна. Монгол улс нь 2021 онд анх удаа иргэний нийгмийн үйл ажиллагааны орчныг сайжруулах НЗТ-ийн үүрэг амлалтыг хэрэгжүүлж эхэлсэн. Цаашдын үйл ажиллагааны төлөвлөгөөнд ч энэхүү хүчин чармайлтыг үргэлжлүүлэн тусган, хэрэгжүүлж болно. Үүрэг амлалтууд нь иргэний нийгмийн оролцогч талуудын зүгээс Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль зэрэг [иргэний орон зайд хамаарах хууль тогтоомжийг](#) боловсруулах үйл явцад оролцох боломжуудыг бүрдүүлэх үүрэг амлалт байж болно. Оролцоот шинэчлэл нь мөн [хүний эрхийг хамгаалагчдыг заналхийллээс хамгаалах](#), ялангуяа уул уурхайн үйл ажиллагааны сөрөг нөлөөнд өртсөн нутгууд болон иргэдийн эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хамгаалж буй хамгаалагчдад хандан хийгдэж болно. Жишээ нь эдгээр арга хэмжээний хүрээнд гадаад улсын тагнуулын байгууллагатай хамтран ажиллах (19.4), хорлон сүйтгэх (19.6) гэмт хэргийн чиглэлээр Эрүүгийн хуульд заасан заалтад хандаж болно.

Хэрэгцээт эх сурвалжууд:

- НЗТ (OGP) Democratic Freedoms Learning Network (Ардчилсан эрх чөлөөний мэдлэгийн сүлжээ)
- НЗТ (OGP): [Actions to Protect and Enhance Civic Space](#) (Иргэний орон зайг хамгаалах, сайжруулах үйл ажиллагаа)
- НЗТ (OGP): [Civic Space and Open Government Reform in Asia Pacific](#) (Ази- Номхон далайн бүсийн иргэний орон зай, нээлттэй засаглалын шинэчлэл)
- НЗТ (OGP): [Civic Space Fact Sheet](#) (Иргэний орон зайн баримтын товч)
- Хамаарах ижил төстэй үүрэг амлалтууд: Нигери ([2019–2022](#)), Люксембург ([2019–2021](#))
- Техникийн туслалцаа үзүүлж болох түншлэгч талууд: [International Center for Not-for-Profit Law](#) (Олон улсын ашгийн бус эрх зүйн төв), [CIVICUS](#) (ИНБ, идэвхтнүүдийн олон улсын эвсэл), [Organisation for Economic Co-operation and Development](#) (Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага)

ЧИГЛЭЛ 2. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдал

2022 оны 12 дугаар сард Монгол улсад нүүрсний салбарт буй авлигын эсрэг олон нийтийг хамарсан [эсэргүүцэл](#) хүчтэй өрнөсөн. Дотоодын эдийн засагт олборлох үйлдвэрлэлийн салбар үндсэн гол үүрэгтэй тул Транспаренси Интернейшнлийн зүгээс эрдэс түүхий эдийн салбарын зохицуулалт дутмаг буй нь Монгол улс тус байгууллагын гаргадаг [Авлигын төсөөллийн индекс](#) дээр түүхэндээ хамгийн доод оноог 2022 онд авахад хүргэсэн хэмээн цохон тэмдэглэжээ. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын (EITI) шаардлагуудын хангасан хоёр дахь улс болох Монгол улс нь НЗТ-ийн Үйл ажиллагааны төлөвлөгөөг ашиглан, Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг батлуулах оролдлого хийж ирсэн ч энэхүү төсөл нь одоогоор зогсонги байдалд ороод байна. ХБТМ-ын зүгээс олборлох үйлдвэрлэлийн салбарын ил тод байдлыг, үүнд эцсийн өмчлөгчийн ил тод байдлыг үүрэгжүүлэх чиглэлээр үргэлжлүүлэн ажиллахыг зөвлөмж болгож байна. Дараагийн Үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас гадна Сангийн яамыг татан оролцуулах замаар энэ чиглэлд дэмжлэг үзүүлж болно. Шинэчлэлийн үйл ажиллагаанд хувийн хэвшлээс гадна иргэний нийгэм оролцох боломжийг өргөжүүлэх нь мөн үр дүнд хүргэнэ. Түүнчлэн дээрх хуулийн төслийг

Монгол улс дахь хамтын оролцоот төлөвлөлтийн товч тайлан (Co-Creation Brief) 2023

эцэслэн батлахаас өмнө тодорхой цоорхой, хийдлүүдийг сайдын тушаалаар засан сайжруулах шаардлагатай байна.

Хэрэгцээт эх сурвалжууд:

- НЗТ: [Extractive Industries Fact Sheet](#) (Олборлох үйлдвэрлэлийн салбарын баримтын товч)
- [OGP Beneficial Ownership Leadership Group](#) (НЗТ-ийн Эцсийн өмчлөгчийн манлайллын бүлэг)
- Нээлттэй өмчлөл (Open Ownership): [Beneficial Ownership Data Standard](#) (Эцсийн өмчлөгчийн өгөгдлийн стандарт)
- Хамаарах ижил төстэй үүрэг амлалтууд: Армени ([2018-2020](#)), Кени ([2016-2018](#)), болон Нигериа ([2019-2022](#))
- Техникийн туслалцаа үзүүлж болох түншлэгч талууд: [Publish What You Pay](#) (Төлсөн авснаа нийтэл), [the Extractive Industries Transparency Initiative](#) (Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга), [the Financial Action Task Force](#) (ФАТФ), [the G20 Anti-Corruption Working Group](#) (Их-20 Авлигын эсрэг ажлын хэсэг) болон [Open Ownership](#) (Нээлттэй эзэмшил)

ЧИГЛЭЛ 3. Төрийн худалдан авах ажиллагаа

Монгол улсад явагдаж буй төрийн худалдан авах ажиллагаа нь авлигын өндөр [эрсдэл](#), тогтмол бус төлбөр тооцоо, ашиг сонирхлын зөрчил зэрэг олон эрсдэлтэй нүүр тулж байна. Сүүлийн жилүүдэд Авлигатай тэмцэх газар, сэтгүүлчид, идэвхтнүүдийн зүгээс төрийн худалдан авалтын дүрэм, журмыг [зөрчсөн](#) олон тохиолдлын талаар мэдээлж байна. Энэ төрлийн нээлтэй гэрээний шинэчлэл хийхэд НЗТ бодит үр дүнг гаргах, үр дүнтэй платформ болох нь [батлагдаад](#) байна. Монгол улсын өмнөх Үйл ажиллагааны төлөвлөгөө ч худалдан авах ажиллагааны онлайн мэдээлэл, өгөгдлийн хүртээмжийг сайжруулах чиглэлд зөв зохистой ч аажим явцтай ахиц дэвшил гаргаад байна. Транспаренси Интернейшнлийн зүгээс гаргадаг [Авлигын төсөөллийн индекс](#) дээр Монгол улс 2022 онд өөрийн түүхэнд хамгийн доогуур оноо авсны дараагаар тус байгууллагын зүгээс худалдан авах ажиллагааны хууль тогтоомжуудыг шинэчлэх болон бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг санал болгоод байна. Дараагийн Үйл ажиллагааны төлөвлөгөө нь энэхүү шинэчлэлд хандах цаг хугацааны хувьд таатай мөч дээр байна. Төрийн худалдан авах ажиллагаатай холбоотой хууль тогтоомжоо шинэчлэн сайжруулсны дараа Монгол улс нь үндэсний түвшинд баримтлах дагалдах дүрэм журмууд, худалдан авалтын стандарт баримт бичгүүдээ [шинэчилж](#), тулмаар төв болон орон нутгийн түвшинд хийгдэж буй төрийн худалдан авах ажиллагаанд хяналт тавих боломжтой юм. Энэ нь худалдан авах ажиллагааны өгөгдлийг эцсийн өмчлөгчийн өгөгдөл мэдээлэлтэй холбож өгснөөр улсын төсвийн зардлын дийлэнхийг авч, үр өгөөж хүртэж буй талуудыг ил тод болгох боломжтой. Төрийн худалдан авах ажиллагааны газар нь тендерийн цаасан баримт бичгүүдийг сканердах бус харин машинд уншигдахуйц, нээлттэй өгөгдлийн форматад шилжүүлж болно. Тус газар нь мөн Цахим хөгжлийн яам болон Төрийн худалдан авах ажиллагааны газар хоорондын салбар хоорондын хамтын ажиллагааг өрнүүлэх замаар хараахан онлайн болоогүй буй төрийн систем дэх сорилт, хүндрэлүүдийг шийдэж, интернэт холболт удаан буй ч иргэд худалдан авах ажиллагааны мэдээллийг авах хүртээмжийг хангах боломжтой.

Хэрэгцээт эх сурвалжууд:

- НЗТ (OGP): [Open Contracting](#) (Нээлттэй гэрээ)

- НЗТ (OGP): [Three Factors to Ambitiously Implement Open Procurement Reforms](#) (Илтөд худалдан авах ажиллагааны шинэчлэлийг хэрэгжүүлэх гурван хүчин зүйл)
- Транспаренси Интернейшнл (Transparency International): [Recommendations on Open Contracting for OGP Action Plans](#) (НЗТ-ийн Үйл ажиллагааны төлөвлөгөөнд зориулсан нээлттэй гэрээний чиглэлийн зөвлөмжүүд)
- Хамаарах ижил төстэй үүрэг амлалтууд: Индонези ([2022-2024](#)), Итали ([2016-2018](#)), Франц ([2015-2017](#)), Шинэ Зеланд ([2022-2024](#))
- Техникийн туслалцаа үзүүлж болох түншлэгч талууд: [Open Contracting Partnership](#) (Нээлттэй гэрээний түншлэл), Азийн Хөгжлийн Банк, [Transparency International](#) (Транспаренси Интернейшнл)

ЧИГЛЭЛ 4. Зөвлөлдөх ардчилал

Монгол улс нь 2023 онд өөрийн [хоёр дахь](#) удаагийн үндэсний хэмжээний зөвлөлдөх санал асуулгыг зохион байгуулжээ. 2017 оноос хойш хийгдсэн хуулийн өөрчлөлтөөр Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт хийх, орон нутгийн тодорхой төслүүдийн санхүүжилт, олон нийтийн орон зайн төлөвлөлт дээр зөвлөлдөх санал асуулга явуулж байхыг хуульчилсан. Дараагийн Үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө дээр Парламентын боловсролын төв нь Монгол улсад зөвлөлдөх санал асуулгын үзүүлэх нөлөөллийг нэмэгдүүлэх үүрэг амлалтуудыг тэргүүлэн ажиллах боломжтой. Жишээ нь тус нэгж нь зөвлөлдөх санал асуудлыг үндэсний хэмжээний бүх нийтийн санал асуулгатай холбох, мөн бүх нийтийн санал асуулга явуулах боломжийг өргөтгөх зэргийг төлөвлөгөөнд харгалзан тусгах боломжтой. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD) нь [Зөвлөлдөх арга замуудыг бэхжүүлэх арга замуудыг](#) боловсруулж, үүнд зөвлөлдөх үйл явцыг хэрэгжүүлэхийг шаардах эрхийг иргэдэд өгөх, тодорхой төрлийн бодлогын шийдвэр гаргахын өмнө зөвлөлдөх арга хэмжээг хийж байх, бодлогын мөчлөгийн туршид зөвлөлдөх арга хэмжээг төлөвлөн хийх эсвэл парламентын чиг үүрэгт зөвлөлдөх явцыг холбох зэргийг тусгасан байдаг. Энэ нь парламентын хувьд Монгол улс дахь нээлттэй засгийн үйл явцад оролцох/ татагдан орох шинэ боломж болж болно.

Хэрэгцээт эх сурвалжууд:

- Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD): [Eight ways to institutionalise deliberative democracy: Overview](#) (Зөвлөлдөх ардчиллыг бэхжүүлэх 8 арга зам: Тойм)
- Роутледж (Routledge): [Deliberative Democracy in Asia](#) (Ази дахь зөвлөлдөх ардчилал)
- НЗТ (OGP): [Five Tips for Weaving Citizen Participation into the Fabric of Government](#) (Иргэний оролцоог төрийн үйл ажиллагаанд нэгтгэх таван зөвлөгөө)
- НЗТ (OGP): [Parliamentary Engagement in National OGP Processes](#) (Үндэсний НЗТ-ийн үйл явц дахь парламентын оролцоо)
- Хамаарах ижил төстэй үүрэг амлалтууд: Шотланд ([2021-2025](#)), Австрали ([2016-2018](#))
- Техникийн туслалцаа үзүүлж болох түншлэгч талууд: [OECD](#) (Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага), [The Citizens' Assembly](#) (Иргэдийн чуулган), [Involve](#) (Оролцоо).